

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2010 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайланг улиралд Хорооны хуралдаанаар 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 7 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 8 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 2 хоршооны эрхийг сэргээж, 23 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэснээр 2010 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 207 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байна.


Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй 207 хоршоодоос 172 буюу нийт хоршооны 83.0 хувь нь зохих журмын дагуу 2010 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 35 буюу 17.0 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь ирүүлээгүйгээс тэдгээрийн Хороонд ирүүлсэн хамгийн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

Жилийн эцсийн байдлаарх ирүүлбэл зохих санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлсэн 172 хоршооны тайлан мэдээг ирүүлсэн хугацаагаар нь авч үзвэл журмын дагуу хугацаандаа ирүүлсэн 75 хоршоо, 10 хүртэл хоног хоцроосон 73 хоршоо, 11-20 хүртэл хоног хоцроосон 24 хоршоо байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа байдлыг харуулбал дараах байдалтай байна.



Хоршооны гишүүдийг тооны хувьд авч үзвэл 2008 оны жилийн эцсийн байдлаар 24,655, 2009 оны жилийн эцсийн байдлаар 28,069, 2010 оны нэгдүгээр улирлын байдлаар 27,132 болж буурсан байна.



Харин 2010 оны нэгдүгээр улирлын байдлаар санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлээгүй 35 хоршооны нэгтгэлд хамруулсан санхүүгийн тайланг цаг хугацааны хувьд нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлант хугацаа	ХЗХ-ын тоо	ХЗХ-ны нэр
1	2008-III	1	Түмэн эрдэс
2	2008-IV	6	Аврагас зоос, Хас итгэл, Цогт жанчхүү, Хорго арвижих, Арвижих цээл, Дэлгэрэх арвай
3	2009-I	6	Элбат, Идэр сэrvэн, Хүнгэлдуут, Техник шинэчлэл, Шинэ зэс, Ар сондор
4	2009-II	1	Буян арвижих
5	2009-III	5	Тосон есөн бүлэг, Хяргас хас, Өгөөмөр хас, Магнаг хэтэвч, Баянлхам
6	2009-IV	16	Очир төр, Идэрийн ундарга, Бидний хөтөч, Ихэр агар, Кайцен, Наранхас булаг, Наранховаат, Солжир хөгжил, Тонхил хөгжил, Дэлүүн бүргэд хайрхан, Баянхайрхан хас, Баянцогт нуур, Дөргөн хөгжил, Манхан хөгжил, Дэвших чулуут, Яах
	Нийт	35	

Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл					Хоршоодын тоо
	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010-1	2	7	8	2	23	207

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгож эхэлснээс хойш 2009 онд 25 хоршооны, 2010 оны нэгдүгээр улирлын байдлаар 23 хоршооны, нийт 48 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасан байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны 1 улирал	2009 оны 1 улирал
1	ХЗХ-дын тоо	207	214
2	Гишүүдийн тоо	27,132	27,020
3	Нийт актив /мянган төгрөгөөр/	44,269,760.3	44,264,832.2
	Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.1%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	34,024,949.7	33,007,607.3
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,165,385.6	2,401,172.9
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	*
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	30,109,975.4	28,627,894.3
	Банкны салбарт эзлэх хувь	2.1%	1.7%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	7,401,896.7	6,994,315.8
	Банкны салбарт эзлэх хувь	3.3%	*

8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,811,308.3	3,504,554.3
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	1.1%	*
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	524,729.2	658,274.7
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	232,171.2	509,757.2
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	3,360,033.8	4,885,276.7
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	3,420,536.2	4,208,200.5
13	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	- 60,502.4	677,076.2
14	Активын өгөөж /ROA/	Тооцох боломжгүй	6.81%
15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	Тооцох боломжгүй	3.48%

Жич: *-тооцох боломжгүй

2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	үндсэн үзүүлэлтүүд	2010 оны 1 улирал
1	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	88
	Гишүүдийн тоо	12,261
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	45.2%
1.1	Нийт актив /мянган төгрөгөөр/	38,118,301.7
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	86.1%
1.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	29,121,737.7
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	85.6%
1.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	2,523,157.3
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	79.7%
1.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	27,299,033.7
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	90.7%
1.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/	5,289,337.3
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	71.5%
1.6	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр/	3,487,921.3
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	91.5%
1.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	83,229.3
1.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	77,915.4
1.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	2,700,079.6
1.1	Нийт зардал /мянган төгрөгөөр/	2,939,322.2
1.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	- 239,242.6

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 88 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 45.2 хувийг, тэдгээрийн нийт актив 38,118,301.7 мянган төгрөг байгаа нь нийт активын 86.1 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 88 хоршоо нь 2,700,079.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 80.4 хувийг, харин 2,939,322.2 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 85.9 хувийг тус тус эзэлж байна.

2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	үндсэн үзүүлэлтүүд	2010 оны 1 улирал
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	119

Гишүүдийн тоо		14,871
<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>		54.8%
2.1	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,151,458.7
<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>		13.9%
2.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,903,212.0
<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		14.4%
2.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	642,228.2
<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		20.3%
2.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	2,810,941.7
<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		9.3%
2.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/	2,112,559.4
<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		28.5%
2.6	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр/	323,386.9
<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>		8.5%
2.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	441,499.9
2.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	154,255.8
2.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	659,954.2
2.1	Нийт зардал /мянган төгрөгөөр/	481,214.0
2.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	178,740.2

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 119 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 54.8 хувийг, тэдгээрийн нийт актив 6,151,458.7 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.9 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 119 хоршоо нь 659,954.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 19.6 хувийг, харин 481,214.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 14.1 хувийг тус тус эзэлж байна.



2.3 Хасбанкны франчайзийн гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны 1 улирал
3	Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо	74
3.1	Нийт актив /мянган төгрөгөөр/	2,864,277.5
<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>		6.5%
3.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	2,288,834.6
<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		6.7%
3.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	134,831.6

ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь		4.3%
3.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	1,350,501.5
ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь		4.5%
3.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/	1,513,776.0
ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь		20.5%
3.6	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр/	1,215,080.3
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь		31.9%
3.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	673,221.7
3.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	6,108.6
3.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	396,088.3
3.1	Нийт зардал /мянган төгрөгөөр/	26,509.9
3.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	130,909.6

Тайлант улиралд Хасбанктай франчайзийн гэрээтэй 74 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагаас Өгөөждулаан хаан, Сүмбэргүн нуур зэрэг 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон. 2009 онд Дорноговь аймгийн Саруулбаян, Архангай аймгийн Хорго арвижих, Ар сондор, Төв аймгийн Арвижих цээл зэрэг 4 хоршооны франчайзийн гэрээг Хасбанк цуцалж байгаа тухай хариуцсан мэргэжилтэн нь мэдэгдсэн боловч албан бичгээр Хороонд мэдээлэл ирүүлээгүй байна.

Франчайзийн гэрээтэй хоршоодын орлого, зарлагын тайлангаас харахад 396,088.3 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт орлогын 11.8 хувийг, харин 26,509.9 мянган төгрөгийн зардал нь нийт зардлын 0.8 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 130,909.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт орлогын хэмжээ 3,360,033.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,525,242.9 мянган төгрөгөөр буюу 31.2 хувиар буурсан нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр гишүүдээс гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар зээл олгохыг хориглосонтой холбоотойгоор гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 1,468,132.8 мянган төгрөгөөр буюу 85.0 хувиар буурсантай холбоотой байна.

Орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд

/мянган төгрөгөөр/

	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	2,882,492.4	85.8%	2,791,992.3	57.2%	90,500.06	3.2%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	2,725,983.2	81.1%	2,649,701.2	54.2%	76,282.0	2.9%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	37,385.6	1.1%	51,273.4	1.0%	- 13,887.8	-27.1%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	82,138.7	2.4%	86,007.4	1.8%	- 3,868.6	-4.5%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	185.4	0.0%	764.4	0.0%	- 579.0	-75.7%
Бусад хүүгийн орлого	36,799.4	1.1%	4,245.9	0.1%	32,553.5	766.7%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	87,309.5	2.6%	160,075.8	3.3%	- 72,766.4	-45.5%
Элсэлтийн хураамж	3,077.0	0.1%	2,901.4	0.1%	175.6	6.1%
Гишүүний татвар	11,496.3	0.3%	12,667.4	0.3%	- 1,171.1	-9.2%
Үйлчилгээний хураамж	27,267.3	0.8%	13,596.2	0.3%	13,671.1	100.6%
Үйл ажиллагааны бусад орлого	45,469.0	1.4%	130,910.9	2.7%	- 85,441.9	-65.3%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	390,231.9	11.6%	1,933,208.6	39.6%	- 1,542,976.6	-79.8%
Торгуулийн орлого	100.0	0.0%	1,491.3	0.0%	- 1,391.3	-93.3%

Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	4,266.7	0.1%	4,985.6	0.1%	- 718.9	-14.4%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	19,309.2	0.6%	-	0.0%	19,309.2	-0.6%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	258,132.5	7.7%	1,726,265.3	35.3%	- 1,468,132.8	-85.0%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	32,631.3	1.0%	50,857.8	1.0%	- 18,226.4	-35.8%
Бусад орлого	44,235.4	1.3%	101,254.0	2.1%	- 57,018.6	-56.3%
Онцгой шинжтэй орлого	31,542.7	0.9%	44,962.5	0.9%	- 13,419.8	-29.8%
Ердийн бус орлого	14.2	0.0%	3,392.1	0.1%	- 3,378.0	-99.6%
Нийт орлогын дүн	3,360,033.8	100.0%	4,885,276.7	100.0%	- 1,525,242.9	-31.2%

Тайлант улиралд нийт орлогын 81.1 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 11.6 хувийг үйл ажиллагааны бус орлого, 2.6 хувийг элсэлтийн хураамж, гишүүний татвар, үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны бусад эзэлж байна.

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт зардлын хэмжээ 3,420,536.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 787,664.3 мянган төгрөгөөр буюу 18.7 хувиар буурсан ба үүнд үйл ажиллагааны бус зардлын өөрчлөлт нөлөөлжээ.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,698,876.5	49.7%	1,646,822.2	60.3%	52,054.3	3.2%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	734,665.1	21.5%	627,429.0	24.5%	107,236.0	17.1%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	794,974.3	23.2%	902,821.5	30.4%	- 107,847.2	-11.9%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	115,824.9	3.4%	38,512.0	1.3%	77,312.9	200.8%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	51,781.3	1.5%	74,367.3	4.0%	- 22,586.0	-30.4%
Бусад хүүгийн зардал	1,630.9	0.0%	3,692.3	0.1%	- 2,061.4	-55.8%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	437,473.9	12.8%	285,456.2	9.5%	152,017.8	53.3%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	435,724.8	12.7%	281,634.3	9.4%	154,090.5	54.7%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	85.9	0.0%	905.1	0.1%	- 819.2	-90.5%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал		0.0%	1,900.6	0.0%	- 1,900.6	-100.0%
Бусад эрсдэлийн зардал	1,663.2	0.0%	1,016.1	0.0%	647.1	63.7%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	693,966.3	20.3%	629,545.9	21.9%	64,420.4	10.2%
Боловсон хүчний зардал	394,425.4	11.5%	326,748.2	11.7%	67,677.2	20.7%
Бусад зардал	299,540.9	8.8%	302,797.7	10.2%	- 3,256.8	-1.1%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	590,219.5	17.3%	1,646,376.3	8.3%	- 1,056,156.8	-64.2%
Торгуулийн зардал	1,642.6	0.0%	1,773.0	0.1%	- 130.4	-7.4%
Ногдол ашгийн зардал	7,948.4	0.2%	4,006.3	0.2%	3,942.1	98.4%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	107.9	0.0%	349.5	0.0%	- 241.6	-69.1%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	522,630.6	15.3%	1,338,412.7	5.5%	- 815,782.1	-61.0%
Үйл ажиллагааны бус бусад зардал	30,139.0	0.9%	263,790.8	0.3%	- 233,651.8	-88.6%
Ердийн бус зардал	111.2	0.0%	175.3	0.0%	- 64.2	-36.6%
Татварын зардал	27,639.8	0.8%	37,868.6	2.2%	-10,228.8	-27.0%
Нийт зардлын дүн	3,420,536.2	100.0%	4,208,200.5	100.0%	- 787,664.3	-18.7%

Тайлант улирлын зардлын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон. Тухайлбал; хүүгийн зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 60.3-49.7 хувь болж

буурсан, харин хүүгийн бус зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 8.3-17.3 хувь болж өссөн байна.

Нийт зардлын 49.7 хувийг хүүгийн зардал, 20.3 хувийг үйл ажиллагааны зардал, 17.3 хувийг үйл ажиллагааны бус зардал, 12.8 хувийг болзошгүй эрсдлийн сангийн зардал эзэлж байна. Харин нийт зардлын 15.3 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал эзэлж байгаа бөгөөд энэ зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 815,782.1 мянган төгрөгөөр буюу 61.0 хувиар буурсан байна.

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Тайлант жилд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын 54 хоршоо буюу 20.8 хувь нь нийт 428,292.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

д/д	Үзүүлэлтүүд	Хоршоодын тоо	Нийт алдагдал	Эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	2	239,189.6	55.8%
2	10,000.0-100,000.0 мянган төгрөг	4	110,553.4	25.8%
3	1,000.0-10,000.0 мянган төгрөг	21	71,407.3	16.7%
4	100.0-1,000.0 мянган төгрөг	21	7,141.7	1.7%
5	100.0 мянган төгрөг хүртэл	6	162.6	0.0%
	Нийт дүн	54	428,454.6	100.0%

Нийт алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 55.6 хувь буюу 30 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 408,609.9 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 95.4 хувийг эзэлж байна.

Орон нутагт алдагдалтай ажиллаж байгаа 24 хоршооны 19,844.7 төгрөгийн алдагдал нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 4.6 хувийг, үүнээс, Хасбангтай франчайзийн гэрээтэй 15 хоршоо нийт 6,635.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 33.4 хувийг эзэлж байна.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хоршоодоос 150 хоршоо буюу 72.4 хувь нь 367,952.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

Ашгийн хэмжээгээр хоршоодыг ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн үзүүлэлтүүд	Хоршооны тоо	Нийт ашиг	Ашигт эзлэх хувь
1	10,000.0-50,000.0 мянган төгрөг	6	166,421.1	45.2%
2	5,000.0-10,000.0 мянган төгрөг	8	58,995.8	16.0%
3	1,000.0-5,000.0 мянган төгрөг	53	113,426.3	30.8%
4	500.0-1,000.0 мянган төгрөг	25	17,560.8	4.8%
5	100.0-500.0 мянган төгрөг хүртэл	41	10,718.1	2.9%
6	100.0 мянган төгрөг хүртэл	17	830.1	0.2%
	Нийт дүн	150	367,952.2	100.0%

Нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 38.0 хувь буюу 57 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн ашиг 169,367.3 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 46.0 хувийг эзэлж байна.

Орон нутагт ашигтай ажиллаж байгаа 93 хоршооны ашиг 198,584.9 мянган төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 54.0 хувийг, үүнээс Хасбанктай франчайзийн гэрээтэй 61 хоршоо нийт 136,480.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын нийт ашгийн 68.7 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хоршоодын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:


ҮЗҮҮЛЭЛТ	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	43,171,777.3	97.5%	40,782,838.0	96.5%	2,388,939.2	5.9%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,052,247.6	18.2%	6,590,406.3	15.6%	1,461,841.4	22.2%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,455,976.9	3.3%	1,592,576.4	3.8%	(136,599.5)	-8.6%
2.Банкинд байршуулсан харилцах	3,852,330.4	8.7%	2,154,352.0	5.1%	1,697,379.9	78.8%
3.Банкинд байршуулсан хадгаламж	2,743,940.4	6.2%	2,808,016.3	6.6%	(64,075.9)	-2.3%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	-	0.0%	0.0	0.0%	598.6	0.0%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	-	0.0%	35,461.6	0.1%	(35,461.6)	0.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	31,879,318.6	72.0%	31,294,718.6	74.0%	584,600.0	1.9%
8. Нийт зээл	34,024,949.7	76.9%	33,007,607.3	78.1%	1,017,342.4	3.1%
8.1.Хэвийн зээл	27,201,702.6	61.4%	28,698,747.3	67.9%	(1,497,044.7)	-5.2%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	3,657,861.6	8.3%	1,907,687.1	4.5%	1,750,174.5	91.7%
8.3.Чанаргүй зээл	3,165,385.6	7.2%	2,401,173.0	5.7%	764,212.6	31.8%
8.3.1. Хэвийн бус	1,417,485.4	3.2%	725,084.4	1.7%	692,401.0	95.5%
8.3.2. Эргэлзээтэй зээл	296,506.4	0.7%	691,602.1	1.6%	(395,095.7)	-57.1%
8.3.3. Муу зээл	1,451,393.8	3.3%	984,486.5	2.3%	466,907.3	47.4%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	(2,145,631.1)	4.8%	(1,712,888.8)	4.1%	(4328742.4)	-3%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,576,328.3	5.8%	2,336,835.2	5.5%	239,493.1	10.2%
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	302,804.8	0.7%	414,601.04	1.0%	(111,796.2)	-27.0%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрсдлийн сан)	42,690.1	0.1%	45,278.96	0.1%	(2,588.8)	-5.7%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,316,213.6	5.2%	1,967,513.12	4.7%	348,700.5	17.7%
БУСАД ХӨРӨНГӨ	170,464.8	0.4%	147,069.3	0.3%	23,395.5	15.9%
12. Материал үнэ бүхий зүйл	121,503.5	0.3%	108,449.7	0.3%	13,053.8	12.0%
14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	16,107.1	0.0%	20,873.8	0.0%	(4,766.7)	-22.8%
15. Бусад актив	32,854.2	0.1%	17,745.8	0.0%	15,108.5	85.1%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	493,417.9	1.1%	413,808.7	1.0%	79,609.2	19.2%
16. Өмчлөх бусад хөрөнгө	540,935.0	1.2%	444,258.9	1.1%	96,676.2	21.8%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	47,517.1	0.1%	30,450.1	0.1%	17,067.0	56.0%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,097,983.0	2.5%	1,481,994.2	3.5%	(384,011.1)	-25.9%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	989,424.0	2.2%	1,362,221.7	3.2%	(372,797.8)	-27.4%
18. Үндсэн хөрөнгө	1,459,091.6	3.3%	1,854,036.9	4.4%	(394,945.3)	-21.3%
19.(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	469,667.7	1.1%	491,815.2	1.2%	(22,147.5)	-4.5%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	108,559.1	0.2%	119,772.4	0.3%	(11,213.3)	-9.4%
20. Биет бус хөрөнгө	30,023.5	0.1%	34,666.8	0.1%	(4,643.3)	-13.4%
21.Бусад	78,535.5	0.2%	85,105.6	0.2%	(6,570.0)	-7.7%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	44,269,760.3	100.0%	42,264,832.2	100.0%	2,004,928.1	-5.6%

Тайлант улиралд активын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс эх үүсвэр 2,004.9 мянган төгрөг буюу 5.6 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал; Зээлийн чанар муудсантай холбоотойгоор чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт

активт эзлэх хувийн жин 5.7-7.2 хувиар, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 4.7-5.2 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Харин зээлийн өрийн үлдэгдэл 1,017.3 мянган төгрөгөөр өссөн боловч, нийт актив өссөлтийн хурдацаас бага байгаагаас нийт актив хөрөнгөд эзлэх хувийн жин 78.1-76.9 хувь болж буурчээ.



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	17,147,828.2	38.7%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	4	10,074,592.4	22.8%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	5,076,055.2	11.5%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	34	7,237,594.7	16.3%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	33	2,416,411.2	5.5%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	82	2,080,155.6	4.7%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	25	187,511.7	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	21	49,611.4	0.1%
	Нийт дүн	207	44,269,760.3	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 500,000.0-17,147,828.2 мянган төгрөгийн активтай нийт 12 хоршооны нийт актив 32,298,475.8 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт активын 73.0 хувийг эзэлж байна.

4.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.03.31		2009.03.31		ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	31,879,318.6		31,294,718.6		(584,600.0)	-1.9%
Нийт зээл	34,024,949.7	100.0%	33,007,607.3	100.0%	(1,017,342.4)	-3.1%
Хэвийн зээл	27,201,702.6	79.9%	28,698,747.3	86.9%	1,497,044.7	5.2%
Хугацаа хэтэрсэн зээл	3,657,861.6	10.8%	1,907,687.1	5.8%	(1,750,174.5)	-91.7%
Чанаргүй зээл	3,165,385.6	9.4%	2,401,173.0	7.3%	(764,212.6)	-31.8%
Хэвийн бус	1,417,485.4	4.2%	725,084.4	2.2%	(692,401.0)	-95.5%
Эргэлзээтэй зээл	296,506.4	0.9%	691,602.1	2.1%	395,095.7	57.1%
Муу зээл	1,451,393.8	4.3%	984,486.5	3.0%	(466,907.3)	-47.4%

(Зээлийн эрсдэлийн сан)	(2,145,631.1)	(1,712,888.8)	(432,742.4)
-------------------------	---------------	---------------	-------------

Тайлант улиралд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,017.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,750,174.5 мянган төгрөг буюу 1.9 дахин өсч нийт зээлийн багцын 5.8-10.8 хувийг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 764,212.6 мянган төгрөг буюу 1.3 дахин хувиар өсч, нийт зээлийн багцын 7.3-9.3 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Зээлийн багцын чанар муудсантай холбоотойгоор зээлийн эрсдлийн сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт 432,742.4 мянган төгрөг буюу 25.3 хувиар өсч, нийт актив хөрөнгийн 4.1-4.8 хувийг эзэлж байгаа нь хоршооны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд: /мянган төгрөгөөр/

д/д	Зээлийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт зээлийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	12,716,302.8	37.4%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	6,989,339.2	20.5%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	8	4,942,681.8	14.5%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	25	4,913,338.6	14.4%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	34	2,343,599.2	6.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	83	1,916,333.0	5.6%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	17	121,068.9	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	29	82,286.2	0.2%
9	Зээлийн үлдэгдэлгүй	7	0.0	-
	Нийт зээлийн дүн	207	34,024,949.7	100.0%

Зээлийн өрийн үлдэгдлийг ангилахад ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 12 хоршооны зээлийн өрийн үлдэгдэл 24,648,323.8 мянган төгрөг байгаа нь нийт хоршоодын олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 72.4 хувийг эзэлж байна.

ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦИЙН ТАЛААР

Хоршоодын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал;

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	33,056,555.3	74.7%	31,765,962.1	75.2%	1,290,593.3	-58.4%
ХАДГАЛАМЖ	30,109,975.4	68.0%	28,627,894.3	67.7%	1,482,081.2	5.2%
1. Хугацаагүй	1,739,815.2	3.9%	1,965,104.6	4.6%	- 225,289.4	-11.5%
2. Хугацаатай	28,370,160.3	64.1%	26,662,789.7	63.1%	1,707,370.6	6.4%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	524,729.2	1.2%	658,274.7	1.6%	- 133,545.5	-20.3%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	522,481.0	1.2%	655,929.5	1.6%	- 133,448.6	-20.3%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	2,248.2	0.0%	2,345.1	0.0%	- 96.9	-4.1%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,189,679.5	4.9%	1,970,036.0	4.7%	219,643.6	11.1%
5. Татварын төлөх өглөг	47,357.4	0.1%	42,843.9	0.1%	4,513.6	10.5%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,830,237.0	4.1%	1,631,533.1	3.9%	198,704.0	12.2%
7. Өглөг	156,416.4	0.4%	209,539.0	0.5%	- 53,122.6	-25.4%
8. Бусад пассив	155,668.7	0.4%	86,120.1	0.2%	69,548.6	80.8%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	232,171.2	0.5%	509,757.2	1.2%	- 277,586.0	-54.5%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	232,171.2	0.5%	509,757.2	1.2%	- 277,586.0	-54.5%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	-			0.0%		
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,213,205.0	25.3%	10,498,870.1	24.8%	714,334.9	14.6%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,401,896.7	16.7%	6,994,315.8	16.5%	407,580.9	5.8%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,401,896.7	16.7%	6,994,315.8	16.5%	407,580.9	5.8%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	3,811,308.3	8.6%	3,504,554.3	8.3%	306,754.0	8.8%
11. Нөөцийн сан	1,439,962.5	3.3%	838,785.6	2.0%	601,176.9	71.7%
12. Дахин үнэлгээний сан	89,614.0	0.2%	375,740.8	0.9%	- 286,126.9	-76.2%
13. Нийгмийн хөгжлийн сан	198,543.2	0.4%	128,974.9	0.3%	69,568.3	53.9%
14. Бусад сангууд	126,244.3	0.3%	133,272.4	0.3%	- 7,028.1	-5.3%
15. Хандив, тусламж	46,785.9	0.1%	52,997.4	0.1%	- 6,211.5	-11.7%
16. Бусад өмч	19,963.0	0.0%	27,037.9	0.1%	- 7,074.9	-26.2%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	(60,502.4)	-0.1%	677,076.2	1.6%	- 737,578.6	-108.9%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	1,950,697.9	4.4%	1,270,669.0	3.0%	680,028.9	53.5%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	44,269,760.3	100.0%	42,264,832.2	100.0%	2,004,928.1	-5.6%

Тайлант улиралд өмнөх оны мөн үеэс гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,482,081.2 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар, хоршоологчдын өмчийн хэмжээ 306,754.0 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар тус тус өссөн. Хоршоологчдын өмчийн өсөлтөд нөөцийн сангийн хэмжээ 601,176.9 мянган төгрөгөөр буюу 71.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Харин банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 191,487.2 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурчээ.

Хоршоодын татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	12,182,054.0	40.5%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	8,082,144.4	26.8%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	4	2,883,658.4	9.6%

4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	20	4,403,070.4	14.6%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	11	863,604.6	2.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	56	1,479,321.4	4.9%
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	47	205,148.8	0.7%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	27	10,973.3	0.0%
9	Хадгаламжгүй	38	0.0	-
	Нийт дүн	207	30,109,975.4	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 8 хоршооны нийт хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 23,147,856.9 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 76.9 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 38 хоршоо буюу нийт хоршоодын 18.4 хувь нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн тайлант улиралд 7,401,896.7 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал дараах байдалтай байна.

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	ХНХ-ийн хэмжээ	Нийт ХНХ-ийн хэмжээнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	2,059,096.8	27.8%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	7	1,571,399.2	21.2%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	20	1,250,567.4	16.9%
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	57	1,719,270.5	23.2%
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	33	392,347.5	5.3%
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	38	277,451.0	3.7%
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	45	129,459.8	1.7%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	5	2,304.4	0.0%
9	Хадгаламжгүй	1	0.0	0.0%
	Нийт дүн	207	7,401,896.7	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 8 хоршооны нийт хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 23,147,856.9 мянган төгрөг нь нийт хадгаламжийн үлдэгдлийн 76.9 хувийг эзэлж байна.

Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмчийн бүтэц дараах байдалтай байна.

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	1,900,000.0 мянган төгрөгөөс дээш	1	1,980,116.0	52.0%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	4	1,126,721.6	29.6%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	4	259,980.0	6.8%
4	10,000.0-50,000.0 мянган төгрөг	32	730,230.7	19.2%
5	1,000.0-10,000.0 мянган төгрөг	92	341,291.2	9.0%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	34	15,719.6	0.4%
7	Хоршоологчдын өмчгүй /алдагдал ихтэй/	40	-642,750.8	-16.9%
	Нийт дүн	207	3,811,308.3	100.0%

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР

ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Үүнд:

/мянган төгрөгөөр/

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ТАЙЛАНГААР	
А АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН			
1	АКТИВЫН ЭРСДЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	2,136,911.4	2,145,631.1 ИЛҮҮ БАЙГУУЛСАН
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	9.3% ХАНГААГҮЙ
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
Б ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	72.0%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	1.1%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.2%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	68.0%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	1.7%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	16.7%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	8.6% ХАНГААГҮЙ
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	571,696.2	1,439,962.5 ИЛҮҮ БАЙГУУЛСАН
В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ			
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	5.1% ХАНГААГҮЙ
Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР			
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	12.6%
Д ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)			
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		9.4%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		33.4%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		61.2%

Хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн хувьд активын эрсдлийн санг 8,719.7 мянган төгрөгөөр илүү байгуулсан, чанаргүй зээлийн зохистой харьцаа 4.3 хувиар хангагдаагүй, нөөцийн санг байвал зохих хэмжээнээс 868,266.3 мянган төгрөгөөр илүү байгуулсан, үйл ажиллагааны зардлын зохистой харьцааг 0.1 хувиар хэтрүүлсэн байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

ДОЛОО. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР


Хорооноос хадгаламж, зээлийн хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах хоршоодын тоо	Эзлэх хувь	Үүнээс	
				УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	128	61.8%	40	88
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	67	32.4%	36	31
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	7	3.4%	7	-
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	5	2.4%	5	-
Нийт дүн		207	100.0%	88	119

Бодит үнэлгээ өгөхийн тулд бүлэг тус бүрээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР


2010 оны нэгдүгээр улиралд нийт 207 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын орон нутгийн байршлыг графикаар харуулбал:



Хадгаламж, зээлийн хоршоодын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээний хавсралт зээл, хадгаламжийн хүүгийн судалгааг 160 хоршоо буюу нийт хоршоодын 77.3 хувь нь гаргаж ирүүлсэн бөгөөд судалгаанаас харахад валютын зээлийн хүүгийн судалгааг гаргаж ирүүлсэн 6 хоршоо байгаагаас валютын зээлийн хүүгийн дээд хэмжээ 2.5-4.0 хувь, валютын зээлийн хүүгийн доод хэмжээ 1.5-3.5 хувьтай байна.

Харин валютын хадгаламжийн хүүгийн судалгааг ирүүлсэн 7 хоршоо байгаагаас валютын хадгаламжийн дээд хүүгийн хэмжээ 0.7-2.5 хувь, валютын хадгаламжийн хүүгийн доод хэмжээ 0.3-0.5 хувьтай байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа системийн хувьд 12.6 хувьтай байна.



Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээг 2007-2010 оны нэгдүгээр улирал хүртэлх байдлаар харуулбал дараах байдалтай байна.



Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 212 хоршоодоос 2009 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 14,447.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 176 хоршооноос 13,111.0 мянган төгрөг буюу 90.7 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт 172 хоршоо 2010 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан ирүүлснийг 2010 оны 5 дугаар сарын 07-ний өдрийн байдлаар хариуцсан хянан шалгагчид хянаж, тайлан ирүүлсэн хоршоодын 91.3 хувь буюу 157 хоршоонд тайлангийн хариуг явуулсан.

Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт хадгаламж, зээлийн хоршооны жилийн эцсийн санхүүгийн тайланг заавал баталгаажуулахаар, Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 2.11 дэх хэсэгт аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байхаар журамласны дагуу 2007 оны жилийн эцэст 179 хоршооноос 22.3 хувь буюу 40 хоршоо, 2008 оны жилийн эцэст 209 хоршооноос 44 хувь буюу 92 хоршоо, 2009 оны жилийн эцэст 212 хоршооноос 43.7 хувь буюу 93 хоршоо санхүүгийн тайлангаа баталгаажуулж, аудитын дүгнэлтийг Хороонд ирүүлсэн байна.

Хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тухайн тайлант хугацааны санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг цаг хугацаанд нь авч хэвшсэнээр нэгтгэлийн тоон мэдээллүүд үнэн зөв гарч, цаашид ямар арга хэмжээ авах талаар зөв бодлого боловсруулах боломжтой.

Иймд цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, мэдээгээ журмын дагуу гаргаж цаг хугацаандаа ирүүлдэггүй, 2 ба 3 улирал дараалан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй хоршоодын үйл ажиллагааг Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”, холбогдох хууль тогтоомжийн дагуу тэдгээрийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авах талаар Хорооны хуралдаанд танилцуулах;
2. Хоршоодыг активын хэмжээгээр 4 бүлэглэж, ангилсны дагуу тухайн бүлэгт хамаарах хоршоодын үйл ажиллагааг харьцуулах замаар тэдгээрийн үйл ажиллагаанд тавих зайн хяналт болон газар дээрх хяналт шалгалтын ажлын чанарыг сайжруулж, бодитой үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах;
3. Хоршооны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоод бүх гишүүдийн хурлыг хуулийн хугацаанд хийж буй эсэх, хуралд оролцож буй гишүүдийн идэвх оролцоо ямар байгаа талаар хоршоодоос ирүүлсэн бүх гишүүдийн хурлын материал болон холбогдох баримт бичигт тулгуурлан судалгаа хийж, удирдлагад танилцуулах;
4. Аудитын тухай хууль, Хорооноос баталсан 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан дээрх журмын шаардлагыг хангуулах үүднээс жилийн эцсийн санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан, журмын хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайлангаа баталгаажуулаагүй хоршоодод захиргааны арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих;

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР